

Профессоруудын хөгжлийн замналд тавигдах ажлын байрны үнэлгээний шалгуур

Энэ бол Шинжлэх ухаан технологийн их сургууль болон тус сургуулийн инженерчлэлийн чиглэлийн салбар сургуулиудын профессоровын хөгжлийн **замналуудад** хүрэх шалгуур үзүүлэлтүүдийн хураангуй юм. Профессоровын хөгжлийн **замналд** орох нэр дэвшигчдийн хувьд зэрэглэл ахих болон хийсэн ажлаа хянан магадалгаанд оруулах хоёуланд нь хамгийн сүүлд сонгон шалгаруулж шалгаснаас хойш үзүүлсэн амжилтад голчлон анхаардаг.

Зэрэглэл, албан тушаал ахих үнэлгээг судалгаа/урлагийн ажил, сургалт ба багшлахуй, нөлөөлөл ба үйлчилгээ (өөрөөр хэлбэл шинжлэх ухааны нийгэмлэг дэх үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний манлайлал, нийгмийн харилцаа) гэсэн үндсэн хэмжүүрүүдээр иж бүрэн үнэлгээг хийдэг. Ажиллах албан тушаалд шууд элсүүлэх нэр дэвшигчдийг тухайн албан тушаалд томилогдох, дэвшихээр шалгагдах профессоруудын адил шалгуураар үнэлдэг.

Профессоровын хөгжлийн **замналд** хүрэх хамгийн бага шаардлага нь:

- Эрдэм шинжилгээ, судалгаа болон/эсвэл урлагийн ажилд **маш-сайн**, мөн **өндөр-чанартай** хичээл заах чадвар, эсвэл
- Сурган хүмүүжүүлэх, хичээл заах чадвар **маш-сайн**, мөн **өндөр-чанартай** эрдэм шинжилгээ, судалгаа болон/эсвэл урлагийн ажил хийх чадвар орно.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн албан тушаалын **хөгжлийн замналыг хянах бодлого, журамд** үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг жагсаасан байх бөгөөд эдгээр нь тухайн ажлын байрны үнэлгээнд онцгойлон анхаарсан байх зүйлүүд бөгөөд мөн судалгаа/урлагийн ажил болон хичээл заах бүх хэсгүүдийн ерөнхий түвшинг (жишээ нь маш-сайн эсвэл өндөр-чанартай) тодорхойлох үндэс суурь болдог. **Эдгээр шалгууруудыг сургуулийн хөгжлийн зэрэглэл тогтоох хорооноос гаргасан жишээ тодорхойлолтуудтай хамт доор үзүүлэв.**

Профессоровын хөгжлийн **замнал** болон албан тушаал ахих хянан магадалгаа хийхэд авч үзэх хүчин зүйлсийн бүрэн жагсаалтыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн **албан тушаалын хөгжлийн замналд мөрдөх бодлого, журмаас** харна уу.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн профессоруудын хөгжлийн замнал тогтоох, дүгнэх шалгуур үзүүлэлтүүд	Салбар сургуулийн шалгуур үзүүлэлтүүд
Судалгаа/Урлагийн ажлын гол шалгуурууд	
Хамгийн чухал хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлүүд, тэдгээрийн чанар , нөлөөлөл, үүнд нэр дэвшигчийн судалгааны чиглэлээр хэвлүүлсэн бүтээлийн жагсаалтын (хэвлүүлсэн бүтээлийн форум) чанар; Эсвэл хамгийн чухал урлагийн бүтээлүүд, тэдгээрийн чанар , нөлөөлөл.	<i>Дараах байдлаар харуулж болно:</i> Хэвлүүлсэн бүтээлийн чанарын өсөлт, судалгааны сэдвийн тууштай байдал, шинжлэх ухааны нөлөөллийн нотолгоо (эшлэл) Профессоровын албан тушаалд нэмэлтээр: Хэвлүүлсэн бүтээлүүдийн чанар болон тооны хөгжсөн байдал, шинжлэх ухааны нөлөөллийн нотолгоо (өндөр эшлэгдсэн өгүүллийн тоо)

Бусад их дээд сургууль, судалгааны институтууд, эсвэл мэргэжлийн холбогдох албан тушаалуудад хийсэн (докторын болон докторын дараах үе шатуудыг оруулаад) судалгааны ажил/урлагийн бүтээл. Ихэнх тохиолдолд тухайн нэр дэвшигч өөр их сургууль, судалгааны хүрээлэнд хамгийн багадаа нэг жил ажилласан эсвэл түүнтэй адилтгах туршлагатай байхыг хөгжлийн замналд шалгаруулж авах шийдвэрт шаардана.	
Нэр дэвшигчийн удирдаж буй докторант, докторын дараах судалгааны хамтрагчид, эсвэл урлагийн мэргэжилтнүүдийг багтаасан судалгаа/урлагийн багийг бүрдүүлэх, удирдах чадвар. Профессорууд (хөгжлийн замнал ахих, дэвших): Нэр дэвшигч болон түүний багийн тухайн судалгааны чиглэл, салбарт олон улсын (болон үндэсний) харагдах байдал, өсөн нэмэгдэж буй байдал.	<i>Дараах байдлаар харуулж болно:</i> Хамгийн багадаа хэд хэдэн докторант оюутан элсүүлсэн, нэг докторантыг төгсгөх хүртэл зөвлөсөн байх Профессорын албан тушаалд нэмэлтээр: Хийж буй судалгааны ажлууд нь шинэ, эсвэл салбар дундын сэдвүүдийг хамарсан эсэх
Өрсөлдөх чадвар бүхий судалгааны санхүүжилтийг, эсвэл урлагийн салбарт өрсөлдөх чадвар бүхий санхүүжилтийг өсгөх чадвар Профессорууд (хөгжлийн зэрэглэл ахих, дэвших): Өрсөлдөөнт санхүүжилтийг авах, амжилтад хүрэх өсөн нэмэгдэж буй байдал.	<i>Дараах байдлаар харуулж болно:</i> Тогтмол хүлээн авдаг гадны судалгааны санхүүжилт, өрсөлдөөнт тэтгэлэгт өргөдөл бэлтгэх Профессорын албан тушаалд нэмэлтээр: Өрсөлдөөнт санхүүжилт авах үйл явцад амжилт гаргасан байдал
Судалгааны/урлагийн ажлын бие даасан үйл ажиллагаа явуулах чадвар.	<i>Дараах байдлаар харуулж болно:</i> Тухайн судлаач олон улсын түвшний судлаач болох боломжтой гэдгийг баталсан гадны шинжээч нарын мэдэгдэл Профессорын албан тушаалд нэмэлтээр: Гадны шинжээчдийн мэдэгдэл нь тухайн судлаач шинжлэх ухаан, технологийн чиглэлээр олон улсын түвшний хүлээн зөвшөөрөгдсөн судлаач гэдгийг тодорхой батлах ёстой бөгөөд үүнийг тодорхой сэдэв, хэвлүүлсэн бүтээл, ололт амжилтаас эш татах замаар нотлох. Олон улсын хэмжээний удирдагчийн хувьд өсөлтийн нотолгоо (олон улсын итгэлцлийн байр суурь, редакцын зөвлөлийн гишүүнчлэл, урилгаар оролцсон илтгэл, амралтын үеэр нь ажиллуулах хүсэлтэй хамтрагч гэх мэт)

Багшлахуй, хичээл заах гол шалгуурууд	Багшлах ажлыг гол төлөв ТСАС-ийн хичээлийн portfolia болон лекцийн үнэлгээнд үндэслэн үнэлдэг.
Доктор, магистр, бакалаврын түвшний төгсөлтийн ажлыг удирдах, багшийн заах чадвар Профессорууд (хөгжлийн замнал ахих, дэвших): Докторын сургалтад үзүүлсэн ололт амжилтад гаргаж буй өсөн нэмэгдэж буй байдал.	
Тухайн чиглэлээр хичээл бэлтгэн хөгжүүлсэн сургалт, туршлагын хөгжүүлэлт. Бүтэн цагийн профессорууд (хөгжлийн зэрэглэл ахих, дэвших): Сургалтын хөтөлбөр хөгжүүлсэн туршлага дахь өсөн нэмэгдэж буй байдал.	
Сурган заах боловсрол болон сургалт.	<i>Дараах байдлаар харуулж болно:</i> Сурган хүмүүжүүлэх чиглэлээр суралцаж төгссөн байдал (захиралтай тохиролцсоны дагуу)
Оюутны санал хүсэлтийн чанар.	
Хамтарсан санал хүсэлт (жишээлбэл тухайн сургалтын хөтөлбөрийн салбар, тэнхимийн эрхлэгч, захирал) болон сурган заах үйл ажиллагааг хөгжүүлэхэд оюутны болон коллегийн санал хүсэлтийг ашиглах.	
Хичээл заах чадвар.	

Нөлөөлөл ба үйлчилгээний ажлын хэсэг дэх профессорын албан тушаалын зэрэглэл ахихыг шалгах шалгуур	Салбар сургуулийн нөлөөлөл ба үйлчилгээний ажлын дэвшлийг шалгах шалгууруудын тодорхойлолт
Мөн нэмэлтээр нэр дэвшигчийн нөлөөлөл ба үйлчилгээний ажилд оруулсан хувь нэмэр, тухайлбал дараах үйл ажиллагаануудыг багтаасан байхыг шаардана: - Нэр дэвшигчийн сурталчилгаа, өөрийн хийсэн ажлын түгээн дэлгэрүүлэлт; - Комисс, ажлын хэсэг, ажлын хэсгийн гишүүн зэрэг ШУТИС, салбар сургууль, салбар, тэнхимүүдийн хүрээнд хамтран ажилласан байдал; - Хамтран ажиллаж буй залуу гишүүд, хамт олонд зөвлөгөө өгөх, сургах; - Академик манлайллыг хөгжүүлэх албан ёсны сургалт; - Комисс, боловсролын хөтөлбөр зэргийг оролцуулан эрдэм шинжилгээний удирдах албан тушаалуудад ажилласан байдал; - Шинжлэх ухаан/урлагийн нийгэмлэг, эсвэл үйлдвэрлэл болон нийгэмд үзүүлсэн үйлчилгээ.	Тухайн хүн ШУТИС-н нийгэмлэг, олон улсын шинжлэх ухааны нийгэмлэг болон/эсвэл ШУТИС-н оролцогч талуудад нэг буюу хэд хэдэн чиглэлээр үйлчилгээ үзүүлэх ёстой. Үйлчилгээний цар хүрээ, чанар нь салбар, тэнхимийн эрхлэгчийн тавьсан зорилттой нийцсэн байна.